



НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын  
газрын данс бүртгэлээс тээврийн  
хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 9,900,000 (есөн сая есөн зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баттүшиг)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баттүшиг)-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА

